



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/186/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: О.Алтансүх

Утас: 99077045 Цахим хаяг: Altansukho52@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН МАЛ
ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА
Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

᠘᠐᠔᠐.᠐᠘.13 № 11/74

танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005020026

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular official stamp is centered. It contains Mongolian text: "Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар" (Baiankhongor Aimgiin Mal Emnelgiin Gasar) at the top, "Хүний нөөц" (Khunii Noeic) in the middle, and "Аудит" (Audit) at the bottom. A large, fluid handwritten signature in black ink is written across the stamp. To the right of the stamp, the name "Б.МӨНХБАТ" is printed.

Б.МӨНХБАТ

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Л.Оюун-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.08-наас 2020.02.10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор О.Алтансүх хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.25-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь “Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл бүс статусаа баталгаажуулах, мал амьтны гаралтай түүхийн эд бүтээгдэхүүний эрүүл эрүүл аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжигч байгууллага болно.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын үйл ажиллагааны чиглэлийг мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, иргэн төвтэй үйлчилгээ, малчинд ойрхон мал эмнэлэг гэж тодорхойлжээ.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Малын эрүүл мэндийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Гүүк Софт ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Dunamic онлайн санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 29 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд,” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1907058,3 мянган төгрөгөөс тооцон 38141,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 529785,1 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал		181811,2	181811,2
Үндсэн хөрөнгө		523494,6	523494,6
Хуримтлагдсан элэгдэл		-16407,9	-16407,9
Нийт хөрөнгө		705305,8	705305,8
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/		705305,8	705305,8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		705305,8	705305,8

Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 186 дугаар тогтоолоор Мал эмнэлгийн ерөнхий газар байгуулагдаж, Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрыг 2019.01.01-ны өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн тул тайлант онд Үндсэн хөрөнгө 42038,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч 283743,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Хүнс хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрийн газраас шилжүүлэн авсан, мөн 206553,9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 386197,3 мянган төгрөгийн бараа материал болон бүтцийн өөрчлөлтөөр 402358,8 мянган төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлэн авсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын өсөлтөд нөлөөлжээ.

2019 онд Монгол улсын Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 28 ны өдрийн А-209 тушаалын дагуу Хүнс, Хөдөө аж ахуйн газрын хөрөнгөнд бүртгэлтэй байгаа 283743,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө. 788556,1 мянган төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан байна.

Биет бус хөрөнгө нь санхүүгийн программ худалдан авсан 1180,0 мянган төгрөгийн өртөгтэй дансанд бүртгэсэн байна.

Өр төлбөр, авлагын дансны үлдэгдэл байхгүй болно.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 529785,1 мянган төгрөг болж өссөн нь бүтцийн өөрчлөлтөөр 2019 онд үйл ажиллагаагаа шинээр эхэлснээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 70801 хөтөлбөрт зориулан Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 663594,6 мянган төгрөгийн санхүүжилт, өөрийн үйл ажиллагааны орлого 2000,0 мянган төгрөгийг оруулсан ба гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагаанд 665144,8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй 490,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн.

Хүснэгт 2. Авсан санхүүжилт, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	663594,6	663104,5	490,0	0,01
Үндсэн үйл ажиллагааны орлого	2000,0	2000,0	0	
Нийт дүн	663594,6	663104,5	490,0	0,01

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Мал Эмнэлгийн Ерөнхий газрын төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 315030,9 мянган төгрөг, Баянхонгор аймгийн Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 517503,5 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр Баянхонгор аймгийн нийт 20 сумын хэмжээнд

бруцеллэз, боом, галзуу гэсэн нэр төрлийн вакциныг төлөвлөгөөний дагуу хийж 832534,4 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 30 эрсдэл тодорхойлж нийт 30 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 258,7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 258,7 сая төгрөгийн алдааг залруулж, 1 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Илрүүлэлт:

2019 оны санхүүгийн тайлангийн аудит хийх явцад үндсэн хөрөнгө, бараа материалын тайлан, тодруулгын дүн санхүүгийн байдлын тайлантай тохирч байсан ч аудит хийх явцад тусгай зориулалтын бараа материалд өндөр үнэтэй үндсэн хөрөнгийн шинж чанартай бараа материал байсныг тулган баталгаажуулав.

Шийдвэрлэсэн нь:

1. 2019 оны бараа материалын тайлангийн тусгай зориулалттай бараа материалыг үндсэн хөрөнгөд бүртгэх нь Сангийн сайдын 2014 оны 03 сарын 14-ны 55 дугаар тушаал “Эдийн засгийн ангилалын тухай” 5-р хавсралт балансын дансны ангилалыг мөрдөж ажиллах гэсэн заалтын дагуу залруулга хийлгэж үндсэн хөрөнгийн дансанд орлогод авхуулав.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллээс хугацаанд нь 145 мэдээллийг, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Тайлбар
1	Бүтэн жил	11	11	8	3		
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	33	3		
5	Тухай бүр	8	96	96			
	Нийт	27	151	145	6		

2019 оны тайлант онд бүтэн жилээр тавих худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Байгууллагын батлагдсан төсөв гэсэн 3 мэдээлэл хугацаа хоцроосон мөн сар бүр оруулах мэдээллийн Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт оруулах 7 сарын мэдээ, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн 7 сарын мэдээ, Төсвийн байгууллагын

батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт тавих мэдээний 7 сарын мэдээг тус тус хугацаа хоцроосон байна.

Хугацаа хоцроосон тайлбарыг нягтлан бодогчоос авахад алдаатай буруу оруулсан мэдээллийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс шалгаж мэдээллийг засуулж оруулснаас хугацаа хоцроосноор бүртгэгдсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Байхгүй

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллага 2019 онд 9550,0 мянган төгрөгийн эм,вакцины худалдан авалт хийж дансанд бүртгэхдээ тусгай зориулалтын бараа материалын дансанд орлого авсан нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангиллын тухай ” 5-р хавсралт балансын дансны ангиллын “ Малын эмчилгээ сувилгаанд хэрэглэгдэх эм, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, дархлаажуулалтын болон малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах хуулийн дагуу урьдчилан сэргийлэх болон халдваргүйжүүлэлтийг хангах вакцин худалдан авах зардлыг эмийн зардалд бүртгэнэ гэсэн заалтыг мөрдөөгүй байв.

1.2. Эрсдэл:

Тайлан үнэн зөв гаргах

1.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид малын эмчилгээ сувилгаанд хэрэглэгдэх эм, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, дархлаажуулалтын болон малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах хуулийн дагуу урьдчилан сэргийлэх болон халдваргүйжүүлэлтийг хангах вакцин худалдан авах орлогыг авч данс бүртгэлд тусгахдаа Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал “Эдийн засгийн ангиллын тухай ” 5-р хавсралт балансын дансны ангиллыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	181811204.61
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	181811204.61
351	Түүхий эд материал	0.00	134140753.61
35110	Тусгай зориулалттай материал	0.00	134140753.61
354	Хангамжийн материал	0.00	45760451.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	4325356.00
35420	Аж ахуйн материал	0.00	41435095.00
35600	Мал амьтад	0.00	1910000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	523494641.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	523494641.37
392	Биет хөрөнгө	0.00	522430891.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.00	64691600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-8745776.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	176348629.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-107112518.70
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	397400120.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-27680927.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	33907800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-6378036.36
393	Биет бус хөрөнгө	0.00	1063750.02
39301	Програм хангамж	0.00	1180000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-116249.98
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	705305845.98
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	705305845.98
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	705305845.98
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	705305845.98
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	705305845.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	705305845.98

3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	2370957309.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	874828289.91
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	874828289.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	874828289.91
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2040300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	872787989.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1496129020.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	663594600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	663594600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	832534420.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	517503500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	315030920.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	1731537577.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	1731537577.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	1715203887.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	79354800.00
210101	Үндсэн цалин	0.00	65834500.00
210102	Нэмэгдэл	0.00	10149300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	3371000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	9919400.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	6745200.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	793600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	634700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	158700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	1587200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	12758700.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1865900.00
210302	Түлш, халаалт	0.00	9000000.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	1892800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	49689053.00

210401	Бичиг хэрэг	0.00	6922800.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	31712200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	3154644.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	360000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	7539409.00
2105	Нормативт зардал	0.00	399824002.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	399824002.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	17329250.00
210604	Урсгал засвар	0.00	17329250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1128231417.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1126804037.81
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	749520.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	315960.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	99000.00
210807	Газрын төлбөр	0.00	262900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	18097263.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1689345.79
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	16407918.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	16333689.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	15843600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	7598600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	8245000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	490089.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	490089.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	639419732.22
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	639419732.22

3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	1498169320.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	2040300.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	2040300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	2040300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2040300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1496129020.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	663594600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	663594600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	832534420.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	517503500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	315030920.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	1456130520.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	1456130520.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	1439796830.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	79354800.00
210101	Үндсэн цалин	0.00	65834500.00
210102	Нэмэгдэл	0.00	10149300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	3371000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	9919400.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	6745200.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	793600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	634700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	158700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	1587200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	12758700.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1865900.00
210302	Түлш, халаалт	0.00	9000000.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	1892800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	49118359.00
210401	Бичиг хэрэг	0.00	10004656.00

210402	Тээвэр, шатахуун	0.00	26831100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	3154644.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	360000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	8767959.00
2105	Нормативт зардал	0.00	22440400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	9550000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	12890400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	20015200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1081200.00
210604	Урсгал засвар	0.00	18934000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1246189971.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1244762591.01
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	749520.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	315960.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	99000.00
210807	Газрын төлбөр	0.00	262900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	16333689.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	15843600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	7598600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	8245000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	490089.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	490089.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	42038800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	42038800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	42038800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	42038800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	42038800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-42038800.00

3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-54,677,650.07	-54,677,650.07
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	54,677,650.07	0.00	54,677,650.07
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	705,305,845.98	705,305,845.98
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	54,677,650.07	650,628,195.91	705,305,845.98

3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	665594600.00	665144810.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	665594600.00	665144810.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	649746000.00	649301210.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	79354800.00	79354800.00
210101	Үндсэн цалин	65834500.00	65834500.00
210102	Нэмэгдэл	10149300.00	10149300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3371000.00	3371000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9919400.00	9919400.00
210201	Тэтгэврийн даатгал	6745200.00	6745200.00
210202	Тэтгэмжийн даатгал	793600.00	793600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	634700.00	634700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	158700.00	158700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1587200.00	1587200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12758700.00	12758700.00
210301	Гэрэл, цахилгаан	1865900.00	1865900.00
210302	Түлш, халаалт	9000000.00	9000000.00
210303	Цэвэр, бохир ус	1892800.00	1892800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49668400.00	49668359.00
210401	Бичиг хэрэг	8649300.00	10004656.00
210402	Тээвэр, шатахуун	24931100.00	26831100.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6410000.00	3154644.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360000.00	360000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9318000.00	9317959.00
2105	Нормативт зардал	22442700.00	22440400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9550000.00	9550000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12892700.00	12890400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52624000.00	52624000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30796000.00	20866000.00
210602	Тавилга	0.00	12824000.00
210604	Урсгал засвар	21828000.00	18934000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	422978000.00	422535551.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	421115100.00	421108171.01
210803	Даатгалын үйлчилгээ	750000.00	749520.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450000.00	315960.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150000.00	99000.00
210807	Газрын төлбөр	262900.00	262900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15848600.00	15843600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15848600.00	15843600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7598600.00	7598600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8250000.00	8245000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	663594600.00	663104510.01
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	663594600.00	663104510.01
122005	Орон нутгийн төсвөөс	663594600.00	663104510.01
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	59.00	54.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	58.00	53.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	53.00	48.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00

3.6 Аудит хийгдсэн Нэмэлт санхүүжилтын тайлан:

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	832,534,420.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	832,534,420.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	832,534,420.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	832,534,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	832,534,420.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	832,534,420.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	832,534,420.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	517,503,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	315,030,920.00

Аудитын тайланг

Хянан:

Тэргүүлэх аудитор

Б.Мөнхбат 2018.02.15

Аудитын менежер

А.Цээням 2018.02.15

Бэлтгэсэн:

Аудитор

О.Алтансүх 2018.02.15